



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 22

Алтай

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Саналын хуудсыг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4, 6, 6 дахь хэсэг, Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын болон аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны сонгуулийн хадгалах хугацаа дуусгавар болсон саналын хуудсыг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Болормаа- Аймагийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

- Гишүүд: А.Баасандаш- Хууль зүйн хэлтсийн дарга
- М.Баттулга- Цагдаагийн газрын дэд дарга
- Д.Энхбат- Тагнуулын хэлтсийн ажилтан
- М.Мандахүү- Архивын тасгийн дарга

2. Хууль тогтоомжид заасны дагуу саналын хуудсыг устгах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, саналын хуудас устгасан тухай тэмдэглэлийн хувийг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга /Л.Болормаа/- д даалгасугай.



ДАРГА

А ДЭЛГЭРЖАРГАЛ